



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/74

Төгөл

Шинжилгээнд хамруулах ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1,1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 23.5 заалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/104 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны А/305 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын бруцеллёз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын хүрээнд азарганаас бусад хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний тандалт шинжилгээг 2024 оны 06 дугаар сарын 12-ний өдрөөс эхлэн 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, шинжилгээнд шаардлагатай хүн, хүч, машин техник, шатахуун болон бусад зардлыг шийдвэрлэж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Хишигсүрэн) ерөнхий нягтлан бодогч (Т.Намжилсүрэн) нарт тус тус даалгасугай.

2. Тандалт шинжилгээнд хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.


3. Тандалт шинжилгээний ажлын явцад хяналт тавин ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Б.Баярмаа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР

/Zahiramj/

Сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/У тоот Захирамжийн хавсралт



Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний 2024 оны малын тоо

№	Сумын нэр	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Хээлтүүлэгч малын тоо				
			Буур	Бух	Хуц	Ухна	Бүгд
1	Улаан-уул сум	Буянт мал хөвсгөл	1	114	120	78	313
2	Улаан-уул сум	Хөгийн голын ундарга	0	73	78	58	209
3	Улаан-уул сум	Бэлтэс	0	68	79	52	199
4	Улаан-уул сум	Алаг хад далайц	0	115	99	68	282
	Нийт дүн						1003

_____ ооо _____